

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/13/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн Аудитын менежер: Л.Магсаржалам
Утас: 88114867 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин.....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 “Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК ба түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	9
3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	11
4.1 Ерөнхий зүйл.....	11
4.2 Материаллаг байдал.....	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
4.4.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
4.5.1 Завсрын аудитын талаар.....	12
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. Аудитын илрүүлэлт.....	12
5.1 Төлбөрийн акт.....	13
5.2 Албан шаардлага.....	13
5.3 Зөвлөмж.....	13
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.15 № 01/272
танай _____ -ны № _____ -т

“ШИНЭ МӨРӨН ХУДАЛДААНЫ ТӨВ”
ОНӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.НАЦАГДОРЖ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөс эс тооцвол “Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Авлага, өр төлбөр дансны үлдэгдэлд тусгасан 65.8 сая төгрөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалттай нийцэхгүй байгаа ба санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 тоот тогтоолоор “2022 оны бизнес төлөвлөгөө”-г батлахдаа 114.8 сая төгрөгийн алдагдалтай баталсан байна.

Аудитын гол асуудал

“Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хууьд заасан хугацаанаас хоцроож ирүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК нь 2022 оны зорилтот түвшний биелэлт 103.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



АЭРДЭНЭБААТАР



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

№ 56/22260439/ХӨА-2023/13
1/НА-СТА-0119

Мөрөн сум

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нар нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацааг хоцроож 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Хаан соёмбо аудит ХХК-д ирүүлсэн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8." Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтуудыг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн захирал Ц.Нацагдорж-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Мөнгөн-Эрдэнэ-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР:

Б.ДАВААНЯМ

1720090001 20 9070605

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

№ 55/АЭЭ10/139/ХАА-2023/13
/НА-ЛТД-ДНД

Мөрөн сум

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нар нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацааг хоцроож 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Хаан соёмбо аудит ХХК-д ирүүлсэн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8." Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтуудыг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн нягтлан бодогч Х.Эрдэнэ-Очирт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн захирал Ц.Нацагдорж-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР:

Б.ДАВААНЯМ



¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0	0
1.1	Эргэлтийн хөрөнгө	109,943,478.36	177,527,217.87
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	65,085,908.03	106,838,228.57
1.1.2	Дансны авлага	17,571,740.14	43,231,665.68
1.1.6	Бараа материал	27,285,830.19	27,457,323.62
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	109,943,478.36	177,527,217.87
	Үндсэн хөрөнгө	5,701,398,259.37	5,544,739,319.16
1.2.1	Биет бус хөрөнгө	96,250,000.00	96,250,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,797,648,259.37	5,640,989,319.16
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,907,591,737.73	5,818,516,537.03
2.1.1.1	Дансны өглөг	7,740,207.64	14,076,764.37
2.1.1.2	Цалингийн өглөг	1,257,811.66	1,487,118.15
2.1.1.3	Татварын өр	22,148,472.79	7,010,004.01
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	160,000.00	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	31,306,492.09	22,573,886.53
2.2	Өр төлбөрийн нийт дүн	31,306,492.09	22,573,886.53
2.3.1	Өмч: - төрийн	5,461,000,000.00	5,461,000,000.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	804,442,672.00	804,442,672.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(389,157,426.37)	(469,500,021.50)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	5,876,285,245.63	5,795,942,650.50
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	5,907,591,737.73	5,818,516,537.03

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	443,231,866.20	512,326,870.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00
3	Нийт ашиг (алдагдал)	443,231,866.20	561,655,693.55
8	Бусад орлого	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	528,905,687.59	641,952,488.68
11	Санхүүгийн зардал	0.00	45,800.00
12	Бусад зардал	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(528,905,687.59)	(80,342,595.13)
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	0.00	(80,342,595.13)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(528,905,687.59)	(80,342,595.13)
24	Орлогын нийт дүн	(528,905,687.59)	(80,342,595.13)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2021 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	5,461,000,000.00	264,242,100.00	(301,941,176.82)	5,423,300,923.18

Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	540,200,572.00	(1,542,428.16)	538,658,143.84
Залруулсан үлдэгдэл	0.00		0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	(85,673,821.40)	(85,673,821.40)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2022 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	5,461,000,000.00	804,442,672.00	(389,157,426.38)	5,876,285,245.62
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	0.00	0.00	(80,342,595.13)	(80,342,595.13)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
2022 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	5,461,000,000.00	804,442,672.00	(469,500,021.51)	5,795,942,650.49

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
6	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	506,241,844.00	535,468,269.09
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	506,241,844.00	483,543,941.00
	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
	Татаас, санхүүжилтын орлого	0.00	0.00
	Бусад мөнгөн орлого	0.00	51,924,328.09
1.2	Мөнгөн зарлага (-)	442,059,614.33	478,416,268.55
	Ажиллагчдад төлсөн	161,692,044.50	205,849,816.35
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	54,661,212.00	23,757,505.16
	Бараа материал худалдан авахад төлсөн	64,460,961.09	62,124,450.00
	Ашиглалтын зардалд төлсөн	92,084,038.08	115,828,374.43
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,916,500.00	7,233,000.00
	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
	Татварын байгууллагад төлсөн	54,244,858.66	57,605,122.61

	Даатгалын төлбөрт төлсөн	5,000,000.00	5,146,000.00
	Бусад мөнгөн зарлага	0.00	872,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	64,182,229.67	57,052,000.54
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	15,299,680.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	15,299,680.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	(15,299,680.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	64,182,229.67	41,752,320.54
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	903,678.36	65,085,908.03
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	65,085,908.03	106,838,228.57

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Үзүүлэлт	2022 оны төлөвлөгөө	2022 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	Нийт борлуулалтын орлого	541,354,000.00	561,655,693.55	20,301,693.55	103.75
1	Худалдааны төвийн орлого	503,454,000.00	525,655,693.55	22,201,693.55	104.41
2	50*100* Цогцолборын орлого	21,400,000.00	19,500,000.00	(1,900,000.00)	91.12
3	Соёмбо Цогцолборын орлого	4,500,000.00	4,500,000.00	-	100.00
4	Бусад орлого	12,000,000.00	12,000,000.00	-	100.00
5	НӨАТ	54,135,400.00	56,165,569.36	2,030,169.36	103.75
1	Нийт үйл ажиллагааны зардал	656,137,000.00	641,952,488.68	(14,184,511.32)	97.84
2	Нийт цалингийн сан	211,741,000.00	188,481,424.00	(23,259,576.00)	89.02
3	НД-ын шимтгэл	28,585,000.00	25,444,992.00	(3,140,008.00)	89.02
4	ТУЗ зардал	27,872,000.00	21,726,228.64	(6,145,771.36)	77.95
5	Томилолтын зардал	5,600,000.00	5,598,128.00	(1,872.00)	99.97
6	Цахилгаан эрчим хүч	65,414,000.00	72,426,912.76	7,012,912.76	110.72
7	Дулаан эрчим хүчний зардал	24,000,000.00	23,650,000.00	(350,000.00)	98.54
8	Цэвэрлэгээ үйлчилгээ	9,575,000.00	9,509,475.00	(65,525.00)	99.32
9	Шуудан холбооны зардал	4,320,000.00	3,584,800.00	(735,200.00)	82.98
10	Ариутгалын зардал	4,245,000.00	3,584,800.00	(660,200.00)	84.45
11	Бохир ус тээврийн зардал	15,820,000.00	15,116,900.00	(703,100.00)	95.56
12	Хог хаягдлын зардал	1,890,000.00	1,750,000.00	(140,000.00)	92.59
13	Шатахууны зардал	9,200,000.00	9,104,168.65	(95,831.35)	98.96
14	Бичиг хэрэг, офиссын зардал	6,643,000.00	6,489,374.23	(153,625.77)	97.69
15	Сургалтын зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
16	Маркетингийн зардал	16,760,000.00	15,800,000.00	(960,000.00)	94.27
17	Аудит төлбөр	2,500,000.00	2,100,000.00	(400,000.00)	84.00
18	Хөдөлмөр хамгааллын зардал	5,973,000.00	5,900,000.00	(73,000.00)	98.78
19	Шагнал урамшуулал, нийгмийн халамжийн зардал	8,550,000.00	8,245,480.00	(304,520.00)	96.44

20	Самбар байрлуулсны газрын төлбөр	500,000.00	480,000.00	(20,000.00)	96.00
21	Засварын зардал	10,107,000.00	9,824,800.00	(282,200.00)	97.21
22	Үндсэн хөрөнгийн элэгдэл	172,246,000.00	184,606,680.48	12,360,680.48	107.18
23	Татвар даатгалын зардал	5,146,000.00	10,337,542.92	5,191,542.92	200.89
24	Газрын төлбөр	2,000,000.00	1,806,802.00	(193,198.00)	90.34
25	50*100-н зардал	8,310,000.00	7,653,180.00	(656,820.00)	92.10
26	Соёмбо цогцолборын зардал	8,140,000.00	7,730,800.00	(409,200.00)	94.97
27	Татварын өмнөх ашиг/ алдагдал	(168,918,000.00)	(80,296,795.13)	88,621,204.87	47.54

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 “Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК ба түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн “Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн зорилго нь Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт суурилсан бодлого төлөвлөлтийг боловсруулж, хамт олны зэрэг, зөв үйлээр удирдах менежментийг хөгжүүлэхэд оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Худалдааны төвийн барилга байгууламжийн ашиглалтын менежментийг харилцан зохион байгуулах
- Тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэх, импортлох, экспортлох зэргээр гадаад дотоод худалдааг эрхлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 100 хувь орон нутгийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

“Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК нь Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 125 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Байгууллага нь үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

- Компанийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай дүрэм журам
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.

“Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн захирлын 2021 оны 07 дугаар сарын 30 өдрийн А/18 тушаалаар дотоод хяналт, шалгалтын нэгжийг томилж, 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/05 тушаалаар дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам болон хяналт шалгалтын ажлыг төлөвлөгөөг баталсан байна. Авлагыг барагдуулах талаар, өмнөх

жилийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар, орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хянах талаар нийт 6 ажил төлөвлөж 90 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу иж бүрэн бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр захирлын тушаалаар баталсан бөгөөд одоогийн мөрдөгдөж буй хууль, журам, тушаалд нь нийцэхгүй байгаа тул 2023 оны 09 дүгээр сарын 1-ний дотор шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

“Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 78.8 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Б			
Мөнгөн хөрөнгө	65.1	106.8	41.8
Авлага	17.6	43.2	25.6
Бараа материал	27.3	27.5	0.2
Үндсэн хөрөнгө	5,797.6	5,641.0	(156.7)
Биет бус хөрөнгө	0.0	0.0	0.0
Нийт хөрөнгө	5,907.6	5,818.5	(89.1)
Өр төлбөр	31.3	22.6	(8.7)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,876.3	5,795.9	(80.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,902.6	5,818.5	(89.1)

Мөнгөн хөрөнгө өмнөх оноос 41.8 сая төгрөгөөр өсч 106.8 сая төгрөгийг тайлант онд тайлагнасан нь түрээслэгчдийн тоо нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Авлага данс тайлант онд өмнөх оноос 25.6 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- 2018 оны үүссэн 3.5 сая төгрөгийн авлага шүүхийн шатанд эрэн сурвалжлагдаж байна
- Өмнөх оны авлага 17.6 сая төгрөг
- Тайлант онд үүссэн 4.5 сая төгрөгийн авлага тус тус байна.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 156.7 сая төгрөгөөр буурчээ.

Богино хугацаат өр төлбөр 8.7 сая төгрөгөөр буурч 22.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна..

3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 119 дүгээр тогтоолын 09 дүгээр хавсралаар “Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан байна. Уг тогтоолоор тайлант оны нийт орлогыг 480.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 647.6 сая төгрөгөөр баталжээ. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор бизнес төлөвлөгөөний нийт орлогыг 541.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 656.1 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 тоот тогтоолоор "2022 оны бизнес төлөвлөгөө"-г батлахдаа төлөвлөгөөний загвар үзүүлэлт дутуу зөвхөн борлуулалтын орлого нийт зардлын үзүүлэлтээр баталсан нь хангалтгүй байна. Бизнес төлөвлөгөөнд Борлуулалтын орлого, нийт зардал, удирдлагын зардал, цалингийн сан, орон тоо, нэг ажилтны дундаж цалин, борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал, өглөг авлага, хөрөнгө оруулалт, улсын төсөвт төвлөрүүлэх татвар хураамж зэрэг үзүүлэлтүүдээр баталж, төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр авлагыг бууруулж ажиллахыг компанийн гүйцэтгэх удирдлагад үүрэг болгож ажиллах ёстой. Үүнээс харахад Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан компанийн бизнес төлөвлөгөө /Зорилтот түвшин/ хангалтгүй гэж үзэж байна. Гүйцэтгэлээр 561.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 641.9 сая төгрөгийн зардал гарган, 83.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Нийт орлогын гүйцэтгэл 561.6 сая төгрөг байгаа нь төлөвлөснөөс 20.3 сая төгрөг буюу 3.7 хувиар их байна. Үүнд: Түрээслэгчдийн тоо нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна..

Нийт зардлын гүйцэтгэл 641.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 14.2 сая төгрөг буюу 2.2 хувиар бага зарцуулсан гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Цалингийн зардлаас 23.2 сая төгрөг хэмнэсэн байна.

Хүснэгт 2. 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

Д-д	Үзүүлэлт	2022		Харьцуулалт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Худалдааны төвийн орлого	503.4	525.6	22.2	104.4
	50*100 Цогцолборын орлого	21.4	19.5	(1.9)	91.1
	Соёмбо Цогцолборын орлого	4.5	4.5	-	100.0
	в/ Бусад орлого	12.0	12.0	-	100.0
2	НИЙТ ОРЛОГО	541.3	561.6	20.3	103.7
3	НИЙТ ЗАРДАЛ	656.1	641.9	(14.2)	97.8
4	Татварын өмнөх ашиг	(243.8)	(77.8)	166.0	31.9
5	Цэвэр ашиг /алдагдал/	(243.8)	(83.0)	160.7	34.0
8	Нийт ажиллагсдын тоо	20	19	(1)	98.0
9	Нийт цалингийн сан	211.7	188.5	(23.2)	89.0
15	НИЙТ АВЛАГА	17.6	43.2	25.6	246.0
16	НИЙТ ӨГЛӨГ	30.7	24.5	(6.2)	79.8
	Үүнээс: Богино хугацаат	30.7	24.5	(6.2)	79.8

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зардлын данстай холбоотой, гэрээ хэлцлийн талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн аудитын менежер Л.Магсаржалам гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

“Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Хаан соёмбо аудитад 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 10.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 7.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 саяас дээш орлогын 30.1 сая төгрөгийн 6 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 саяас дээш зарлагын 68.3 сая төгрөгийн 11 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 382.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 248.6 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 134.2 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн биелэлтийг бүрэн хангаж, шилэн дансны тухай хуультай холбоотой 1 албан шаардлагын биелэлтийг хангаагүй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
				Дүн	Хувь
Албан шаардлага	2	248.6	1	77.3	50
Зөвлөмж	7	134.2	7	134.2	100
Нийт дүн	9	382.8	8	211.5	88.8

/сая төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд нягтлан бодогчийг 4 удаа сольж томилсон нь санхүүгийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсэн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 295.9 сая төгрөгийн алдаа илэрснээс, 295.9 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- 2022 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдлийг 2021 онд хийсэн аудит хийсэн тайлантай тулгаж үзэхэд авлага 91.8 сая төгрөг, бараа материал 4.8 сая төгрөг, үндсэн хөрөнгө-3.2 сая төгрөг, дансны өглөг-1.9 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн танилцуулга буруу илэрхийлэгдсэн ба "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд ирүүлсэн санхүүгийн байдлын тайланд авлага 13.6 сая төгрөг, бараа материал 1.1 сая төгрөг, үндсэн хөрөнгө 9.2 сая төгрөг, дансны өглөг 11.8 сая төгрөг, орлогын дэлгэрэнгүй тайланд борлуулалтын орлого 107.2 сая төгрөг, ерөнхий удирдлагын зардал 89.1 сая төгрөг, санхүүгийн зардал 0.05 сая төгрөг, мөнгөн хөрөнгө дансанд орлого 28.2 сая төгрөг, мөнгөн зарлага 13.5 сая төгрөгөөр, өмчийн өөрчлөлтийн тайлан 12.0 сая төгрөгөөр зөрүүтэй байсан нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн танилцуулга буруу илэрхийлэгдсэн ба "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байсныг залрууллаа.

Аудитаар нийт 288.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1 зөрчил албан шаардлага хүргүүлж, 288.1 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

“Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК нь санхүүгийн тайлангаа хугацаа хоцроож ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх заалтыг зөрчсөн, “Тасалбар болголт” батламж мэдэгдлийг хангаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аж ахуйн нэгж, иргэнээс авах 43.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэл нь хэнээс хэдэн төгрөг авах нь тодорхойгүй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар тодорхой бүртгэн баталгаажуулж байх.

2. Өр төлбөр данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аж ахуйн нэгжид 22.6 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар тодорхой бүртгэн баталгаажуулж байх.

3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэлтэйгээр 9.1 сая төгрөгийн шатахуун зарцуулсан боловч тооцоо бодолт хийгээгүй, замын хуудсанд спидометрийн заалтыг бүрэн хөтлөөгүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахуун зарцуулалтын тооцоог хийн, үр дүнг санхүүгийн тайланд тусгаж, замын хуудсанд спидометрийн заалтыг зөв илэрхийлж байх.

4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Татварын зөрүүгийн тайлан бэлтгэж, татварын зөрүүг санхүүгийн тайланд тусгаагүй нь Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр “Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам, тайлангийн маягт, аргачлал батлах тухай” тушаалыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалын дагуу татварын зөрүүгийн тайланг бэлтгэж, санхүүгийн тайланд тусгах.

5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2018 онд боловсруулан мөрдөж байгаа нягтлан бодох бодлогын баримт бичиг нь одоогийн мөрдөгдөж буй хууль, журам, тушаалд нь нийцэхгүй байгаа бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх.

6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 тоот тогтоолоор “2022 оны бизнес төлөвлөгөө”-г батлахдаа 114.8 сая төгрөгийн алдагдалтай баталсан нь Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан компанийн бизнес төлөвлөгөө /Зорилтот түвшин/ хангалтгүй, Компанийн тухай хуулийн 76.1.1, 76.1.9, 81.4.1 заалтуудыг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн тухай хуулийн 76.1.1, 76.1.9, 81.4.1 заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 саяас дээш орлогын 6 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 саяас дээш зарлагын 11 гүйлгээ, нийт 98.4 сая төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5 дугаар заалтыг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 зүйлийн дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5, хэсэгт заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээлж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Оны эхний санхүүгийн тайлангийн танилцуулга буруу илэрхийлэгдсэн	1	10.0			1	10.0	1	10.0				
Тайлант оны санхүүгийн тайлангийн танилцуулга буруу илэрхийлэгдсэн	1	285.9			1	285.9	1	285.9				
Нийт дүн	2	295.9			2	295.9	2	295.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангаа хугацаа хоцроож ирүүлсэн	1	-			1	-						
Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй.	1	43.2					1	43.2				
Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй	1	22.6					1	22.6				
Шатахуун зарцуулалтын тооцоог хийгээгүй, үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй, замын хуудсанд спидометрийн заалтыг өмнөхөөс зөрүүтэй бичсэн	1	9.1					1	9.1				
Татварын зөрүүгийн тайлан бэлтгэж, татварын зөрүүг санхүүгийн тайланд тусгаагүй	1	-					1	-				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шаардлага хангаагүй	1	-					1	-				
Бизнес төлөвлөгөөг батлахдаа төлөвлөгөөний загвар үзүүлэлт дутуу зөвхөн борлуулалтын орлого нийт зардлын үзүүлэлтээр баталсан	1	114.8					1	114.8				
Нийт	7	189.7			1	-	6	189.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроосон	1	98.4					1	98.4

АУДИТЫН ТАЙЛАНГ
ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Х.ДИЙМАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Л.МАГСАРЖАЛАМ

